

МЭДЭЭЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛТ ОЙ

Мэндэлсний нь 125 жилийн ойд

СЭН КАТАЯМАГИЙН ҮЙЛ АМЬДРАЛААС

Японы болон олон улсын коммунист, ажилчны хөдөлгөөний нэрт зүтгэлтэн, дайн, фашизмын эсрэг цогтой тэмцэгч Сэн Катаямагийн амьдралын замнал нь марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчимд үнэнч байхын үлгэр дууриал мөн.

Сэн Катаяма* 1859 оны арванхоёрдугаар сарын 3-нд Японы Мимасака мужийн Хадэги тосгонд тариачны гэр бүлд төржээ. Хүүхэд ахуй цагаасаа тариачны хүнд хүчир хөдөлмөр, ядуу зүдүү амьдралыг биеэрээ үзэж, 15 настайдаа бага сургуулийн нэгдүгээр ангид орсон боловч үргэлжлэн удаан суралцаж чадсангүй. Амьдралын эрхээр тэр сургуулиа орхиж, Токиод очиж үсэг өрөгч, манаач зэрэг ажил хийж байв. Идэр залуу насандаа туулсан энэ амьдрал нь түүнийг гуйланчлал, ажилчин, тариачдын хүнд хүчир, эрх чөлөөгүй байдал, японд ноёрхож байсан бурангуй дэглэмийн харгис мөн чанарыг ухааран ойлгож, эсэргүүцэн тэмцэх санаа бодлыг төрүүлсэн ажээ.

Боловсрол олохын тулд Сэн Катаяма 1884 онд АНУ-д очоод өөрийгөө тэжээх гэж зарц, тогооч зэрэг ажил хийхийн зэрэгцээ их сургуульд суралцаж төгсгөжээ. «Би зүсэм талх олохын тулд шал угаах, баячуудын тогооч, зочид буудал, ресторанд үйлчлэгч хийх, өвс хадах, газар хагалах, цагаан будаа тарих зэрэг ажил хийж байлаа»¹ гэж Сэн Катаяма Америкт байсан үеэ хожим хойно дурсан бичсэн байна.

1896 онд Сэн Катаяма эх орондоо буцаж иржээ. Энэ үед Японд ажилчны ба үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн өрнөж байлаа. Энэ хөдөлгөөнийг либерализм, социал-рефоризмийн нөлөөнөөс ангижруулахын төлөө Сэн Катаяма идэвхтэй тэмцэн, Японы ажилчны «Родо сэкай» нэртэй сэтгүүлийн редактор нь болж, түүндээ ажилчин ангийн эв нэгдэл, социализмын үзэл санааг идэвхтэй сурталчилж байв.

Сэн Катаяма Японы ажилчин ангийн биеэ даасан байгууллагын эхийг тавьсан бөгөөд түүнийг «японы үйлдвэрчний эвлэлийн эцэг» гэж үздэг юм. Тэрээр Японы ажилчны хөдөлгөөнд социализмын үзэл санааг дэлгэрүүлэхэд биечлэн оролцож байв. 1911 оны 12-р сард То-

* Сэн Катаямагийн жинхэнэ нэр нь Сугатаро Ябуки бөгөөд 1878 онд японы эзэн хааны армид татагдахаас чөлөөлөгдөх гэж зэргэлдээх тосгоны тариачин Икутаро Катаямагийн өв залгамжлах өргөмөл хүү нь ёс төдий болсноор эцгийн нэр нь Катаяма гэгдэж, 1896 онд Японд буцаж ирснийхээ дараа Сугатаро Сэн болгон сольжээ.

¹ И.И. Коваленко. Очерки истории коммунистического движения и Япон до второй мировой войны. М., 1979, с. 36.

киод трамбайны 6 мянган ажилчдын томоохон ажил хаялт болж, тавьсан шаардлагадаа хүрч чадсан билээ. Энэ ажил хаялтыг зохион байгуулсны учир Сэн Катаямаг 9 сар шоронд хорьжээ. Харгис цагдаагийн газрын байнгын мөрдлөг хавчлагаас болж 1914 онд Сэн Катаяма төрөлх Япон орноо орхин АНУ-д очсон байна.

1917 онд Орос оронд ялсан Аугаа их Октябрийн социалист хувьсгал нь улс түмэн капитализмаас социализмд шилжин орох эрин үеийг нээсэн билээ. Октябрийн хувьсгалыг Сэн Катаяма чин сэтгэлээсээ талархан дэмжиж байлаа. Чухамхүү Октябрийн хувьсгал л Сэн Катаямагийн хувьсгалт тэмцлийн цаашдын зөв замыг зааж өгсөн байна. Сэн Катаяма 1920 онд В. И. Лениний «Төр ба хувьсгал» хэмээх зохиолыг анх япон хэл рүү орчуулжээ. «Энэ ном надад Октябрийн хувьсгалын жинхэнэ программ, капитализмаас коммунизмд шилжих программыг зааж өгсөн юм»² гэж Сэн Катаяма хожим нь дурсан бичжээ.

Сэн Катаяма японы ажилчин анги, тариачидтай ямагт нягт холбоотой байсан төдийгүй япон дахь ажилчны ба коммунист хөдөлгөөний нийтэд алдаршсан зохион байгуулагч, японы коммунист намыг үндэслэн байгуулагч, түүний удирдагч нь байлаа.

1918—1919 онд Сэн Катаяма АНУ дахь Японы ажилчид, оюутны коммунист группийг зохион байгуулж, улмаар АНУ-ын Коммунист намыг үндэслэн байгуулахад биечлэн оролцож, түүний анхны нь Төв хорооны гишүүнээр сонгогдож байв. Харгис цагдаагийн мөрдлөг хавчилгаас болж Сэн Катаяма 1921 онд Мексикт очиж, тэнд Коминтерний америкийн товчоог толгойлж байхдаа Мексик, Канадын коммунист намыг үндэслэн байгуулахад оролцжээ.

1921 оны 12-р сард Сэн Катаяма Москвад ирж, амьдралынхаа сүүлчийн мөчийг хүртэл ЯКН-ыг төлөөлөн Коминтерний Гүйцэтгэх Хороонд ажиллаж байв.

1922—1933 онд Коминтерний удирдлагад байхдаа Сэн Катаяма Коминтерний III их хурал дээр В. И. Лениний шууд оролцоотойгоор боловсруулсан ажилчны нэгдсэн фронтын тактик болон дайн, фашизмын эсрэг тэмцэлд өргөн олныг дайчлан оролцуулах тухай Коминтерний шийдвэрийг практикт хэрэгжүүлэхийн тулд ихээхэн ажил хийжээ. «Хувьсгал, коммунизмын үйл хэрэгт өөрийгөө зориулахад л миний амьдралын утга учир оршино...Хэрвээ би коммунизмын үйл хэргийн төлөө ажиллаж чадахгүй юм бол үхсэн нь дээр. Коммунизм бол миний амьдрал мөн»³ гэж Сэн Катаяма амьдралынхаа зорилгыг тодорхойлсон нь түүний амьдрал, үйл ажиллагаа чухам ямар байсныг бүрэн дүүрэн харуулж байна.

Сэн Катаяма империалист дайн, фашизм, милитаризмын эсрэг шантаршгүй тэмцэгч байлаа. Бүр 1904—1905 оны орос-японы дайны эсрэг суртал ухуулгын ихээхэн ажил хийж байв. Дэлхийн I дайны жилүүдэд дайны эсрэг интернационалч хөдөлгөөний эхлэлийг тавьж, залуу Зөвлөлт Оросыг устгах гэсэн олон улсын харгис хүчний зэвсэгт халдлагын эсрэг шийдэмгий тэмцэж байлаа. 1922 онд Японы цэргүүдэд хандан гаргасан ухуулах хуудаснууддаа Зөвлөлтийн Алс Дорнод руу өнгөлзөж буй японы милитаризмын мөн чанарыг илчлэн шүүмжилж, япон цэргүүдийг эх орондоо даруй буцахыг уриалж байв. Тэрээр олон тооны илтгэл, өгүүлэлдээ империалист дайн, харгис хүчний

² О. Куусинен. Знаменосец японского пролетариата в международном коммунистическом движении. «Правда» 1959. XII.3.

³ А. Абрамов. У. Кремлевской стены. М, 1984. с. 200

эсрэг бүх дэлхийн хөдөлмөрчин олон түмэн нэгдэн нягтрахыг уриалж байлаа. Тэрээр империализмыг эсэргүүцсэн холбооны дэлхий дахины 1927 оны Брюсселийн их хурал, дайныг эсэргүүцсэн 1929 оны Майн дахь Франкфурт, 1932 оны Амстердамын олон улсын их хуралд оролцож, империализм, түүний дотор японы милитаризмын түрэмгий төлөвлөгөө, дайны аюул заналын эсрэг, даян дэлхийн энх амгалан байдлын төлөө тэмцэж байлаа.

Сэн Катаяма колончлол, үндэсний дарлалын эсрэг, улс түмний тусгаар тогтнол, эрх чөлөө, ардчилсан эрхийн төлөө цогтой тэмцэгч байв. Тууштай интернационалч Сэн Катаяма нь монголын ард түмний дотнын анд нөхөр бөгөөд тэрээр монголын хувьсгалын хөгжлийн явц, хэтийн төлөвийн асуудалд онцгой анхаарал тавьж, БНМАУ-ын эрх чөлөө, тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлтэнд ЗХУ-тай ах дүүгийн найрамдал, нягт хамтын ажиллагаагаа өргөжүүлэн гүнзгийрүүлэхийн чухлыг МАХН, Монголын ард түмэнд зөвлөж байжээ.

1922 оны 1-р сарын 21-нд Москвад нээгдсэн Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын анхдугаар их хурлын үеэр Сэн Катаяма Монголын төлөөлөгчидтэй уулзаж танилцан, монголын хувьсгалын явц, хэтийн төлөвийг анхааран сонирхож байжээ. Энэ хурлын үеэр В. И. Ленин Дорнодахины хувьсгалт хөдөлгөөний төлөөлөгч болох солонгос, монгол, хятад, япон зэрэг орны хүмүүсийг хүлээн авч уулзсаныг Сэн Катаяма «н. Ленин бидэнтэй нэг бүрчлэн ярилцаж, тухайн улс орон бүрийн хувьсгалт ажилчны хөдөлгөөний онцлог нөхцөл хийгээд алс дорнодын ажилчны хөдөлгөөний талаархи ерөнхий асуудлыг хэлэлцэв»⁴ гэж тэмдэглэн бичжээ. Энэ уулзалтын үед В. И. Ленин монголын төлөөлөгчидтэй ярилцсан яриаг Сэн Катаяма англи хэлнээс япон хэл рүү орчуулан өөрийнхөө төлөөлөгчдөд танилцуулж байжээ.

Коминтерний IV их хурал дээр (1922 оны арван нэг, арван хоёрдугаар сар) Сэн Катаяма Алс Дорнод дахь хувьсгалт үйл явц нь МАХН-ын удирдлагаар эрх чөлөө, тусгаар тогтнолоо байлдан олсон монголын ард түмний хувьсгалт хөдөлгөөнтэй нягт холбоотой байхын чухлыг заан тэмдэглэж байлаа.

Сэн Катаяма 1925 онд манай оронд ирж МАХН-ын үйл ажиллагаа, хувьсгалт ололт, монголын ард түмний аж байдал өвөрмөц онцлогтой биечлэн танилцаж байлаа.

МАХН-ын Төв Хороо нөхөр Сэн Катаямаг гүн хүндэтгэлтэй хүлээн авч уулзаад Коминтерний Гүйцэтгэх Хорооны тэргүүлэгч гишүүн Сэн Катаяма манай оронд ирсэн явдал бол «МАХН ба олон улсын коммунист хөдөлгөөний холбоог бэхжүүлэхэд чухал үйл явдал болж байна гэж үзэж, түүнийг МАХН-ын гишүүнээр элсүүлж авчээ»⁵.

1925 оны 4-р сарын 1-нд Улаанбаатар хотын Ардын цэнгэлдэх хүрээлэнгийн газарт болсон МАХН ба эвлэлийн гишүүдийн хурал дээр Сэн Катаяма илтгэл тавьжээ. Сэн Катаяма Монгол Ардын хувьсгал бол Октябрийн хувьсгалын шууд үргэлжлэл, дэлхийн хувьсгалт үйл явцын салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөнийг дурдаад, БНМАУ-ыг тунхагласны ач холбогдол, монгол-зөвлөлтийн найрамдлыг цохон тэмдэглэж хэлэхдээ: «...Умард их Орос улсын Октябрийн хувьсгалын явдал

⁴ Сэн Катаяма. Ленинтэй анх уулзсан минь. «Дорнодахины судлалын асуудал» 1983. № 1 (8). 101-р тал.

⁵ МАХН ба коммунист интернационал. УБ., 1979, 186-р тал. «Намын амьдрал», 1959, № 12, 52-р тал.

туйлд хүрсэний ачаар Ази тивд анх хувьсгалыг явуулан тусгай улс болсон нь танай Монгол улс мөн.

Оросын үйлдвэрчин, тариачнаас танай хувьсгалын явдалд ихээр тусалсан ба мөн танай монголчууд оросын харгис цагаан намын муу хулгай нарыг хязгаараас үүсгэн хядан арилгаж, дарангуйлан сөнөөж, харилцан хүчнийг хавсран туслалцаж гүйцэтгэсэн зэргийн гавьяа нь Оросын эв хамт нам ба Зөвлөлийн засагт улсын Сибирь хязгаарын бүхий цагаан намын хулгайг сөнөөх явдалд дөхөм болжээ. ...Танай хувьсгалт улс Орос улсын хувьсгал Алс Дорнодод дэлгэрэх үүд нь мөн бөгөөд, тиймийн тул танай монгол хувьсгалч улс ба ард түмэн, Зөвлөлийн засагт бүгд найрамдах холбоот улс лугаа хэзээд зузаан холбоотой байваас зохино»⁶ гэжээ.

Сэн Катаяма дэлхийн хувьсгалын их жолоодогч В. И. Ленинтэй 3 удаа уулзаж ярилцсан бөгөөд Лениний амьдрал, Ленинизмийг судлахын ач холбогдлыг ямагт онцлон тэмдэглэж байв. «Бид Ленинизмийг судлах төдийгүй, энэ сургаалыг бүтээн бий болгосон тэр хүний амьдралыг судлах хэрэгтэй. Ленин, ленинизмийг судлах нь их удирдагчийн үйл хэргийг үргэлжлүүлэхэд бидэнд тусална»⁷ гэж Сэн Катаяма бичжээ. «Ленинизмийн суртал (үзэл санаа Л. Б.) чадал нь бүх дэлхийн эзэрхэг түрэмгийг сөнөөх гагцхүү зэвсэг, энэхүү суртал ямар ч боолт хаалт, зэвсэг, уул хад, ус далайг нэвтлэн дэлхийн түмэн ардын дотор дэлгэрэх хүчтэй болой»⁸ гэж Сэн Катаяма цохон тэмдэглэж байв.

Сэн Катаяма марксизм-ленинизмийн түгээмэл зүй тогтлыг Дорнодахины, түүний дотор японы тодорхой нөхцөлд бүтээлчээр хэрэглэхийн чухлыг онцлон зааж байв. Тэрээр японы ба олон улсын ажилчны хөдөлгөөн, империализм, түрэмгий дайны эсрэг, колонийн ба үндэсний асуудал, япон дахь тариачны хөдөлгөөн, Алс Дорнод дахь олон улсын харилцаа болон бусад олон асуудлаар 700 гаруй бүтээл туурвисан томоохон онолч хүн юм.

Японы ард түмний агуу их хүү Сэн Катаяма 1933 оны 11-р сарын 5-нд 74 насандаа таалал төгссөн боловч түүний эрэлхэг хувьсгалч, интернационалч, энх тайвны төлөө цогтой тэмцэгч, үйл ажиллагаа нь орон бүхний коммунистууд, ажилчин анги, хөдөлмөрчдийг шинэ хувьсгалт үйл ажиллагаанд улам бүр уриалан зоригжуулж байна.

Коммунизмын үйл хэргийн ялалтын төлөө, ардчилал, эрх чөлөөний төлөө мятрашгүй тэмцэгч, японы ба олон улсын коммунист, ажилчны хөдөлгөөний нэрт зүтгэлтэн Сэн Катаямаг японы болон дэлхийн бусад орны хөдөлмөрчдийн нэгэн адил монголын ард түмэн гүнээ хүндэтгэн дурсаж байдаг юм.

Л. Бэгзжав

⁶ Сэн Катаямагийн илтгэл. «Үнэн» 1925 оны IV сарын 23. № 1.

⁷ «Правда» 1959.XII.3.

⁸ «Үнэн», 1925.IV.23. №1.